

Халдвартай зүйлс бөдөх үхсэн юм уу устгасан мал амьтан, тээвэрлэсэн автомашины тэвшний өтөг шивх, сангас, өндөг, өвс, тэжээлийг хамтад нь газрын хөрсний 250-300 см-ийн гүнд булна.

Нүүний ёролд устгасан мал, амьтан, шувуу гүе болгон байрлуулж дээр нь халдваргүйжүүлэх бодисыг үелүүлэн цацах юм уу шуршина. Энэ ажиглаганы дараа нүүхийг 50 см-ээс доошгүй зузаан хөрсөөр дүүртэж сайтар чигчинэ. Нүүхийг шороогоор дүүртэж чигжиж дараа нь газрын гадаргаас дээш 50 см өндөр шороо овоолсон байна. Бод, бог малын хүүрийн гэдсийг нүхэнд хийсний дараа зүсэж хагална.



### Мал, амьтны эрүүл мэндийн алба

Төв Зуунмод сум Номт 1-р баг

Утас: 70272361

Цахим хаяг: <http://vet.to.gov.mn/>



**МАЛ, АМЬТНЫ ХҮҮР, СЭГ  
ЭМНИЙГ УСТГАХ АРГА ЗҮЙН  
ЗӨВЛӨГӨӨ**



# СЭГТЭМ УСТТАЛ

Хүн, малын халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, отор нүүдэл, өвөлжилт хаваржилтийн хүндрэл, зүй бусаар болон байгалийн гамшгийн улмаас хоролдсон мал, амьтны сэг зэмийг устгахад гол зорилго оршино.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/52 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт "Мал, амьтны хүүр, сэг зэм устгах үйл ажиллагааны заавар"-ыг мөрдөж ажиллана.

## МАЛ, АМЬТНЫ ХҮҮР, СЭГ ЗЭМ УСТГАХ:

- Мал, амьтан нь гоц халдварт, халдварт өвчнөөр өвчилсөн болон хоролдсон тохиолдолд мал эмнэлгийн байгууллага зориудаар устгах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Зүй бусаар болон байгалийн гамшгийн улмаас хоролдсон мал, амьтны хүүр, сэг, зэмийг магчин, мал бүхий иргэд булаах, шатаах зэргээр устгана.



## БУЛШЛАХ АРГА:

Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ орон нутгийн засаг захиргааны нэгж, бусад холбогдох албадтай харилцан зөвшилцөн хүүр, сэг, зэм устгах арга, булшлах газрыг сонгон халдваргүйжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Булшлах газрыг сонгохдоо хөрөнний ус, нуур, голын эргээс хол, улсын болон орон нутгийн чанартай авто болон төмөр зам, нутгийн шүтлэгтэй уул, овооноос зайдүү, мал, хүний суурьшил сийрэг, үерийн усанд автахгааргүй, өндөрлөг, хуурай хөрстэй, зонхилох салхины чиглэлийн эсрэг талд байрлах зэрэг газрыг сонгоно.

## Булшлах үйл ажиллагаанд дараахь үндсэн 2 аргыг дангаар буюу хослон хэрэглэнэ.

- **Шатааж хөрсөнд булшлах:** Энэхүү устгах аргыг техникийн нөхцөл боломж бүрдсэн тохиолдолд л хэрэглэнэ. Энэ арга нь их хэмжээний түлш, шатаах материал, цаг хугацаа шаарддаг учир хязгаарлагдмал байлцаар хэрэглэнэ. Өвлийн улиралд шатамхай бодис (бензин, дизелийн түлш, креосин) мод зэргийг ашиглаж болно. Боом, дуут хавдар өвчнөөр үхсэн малыг булшлахад энэ аргыг хэрэглэнэ.



- **Хөрсөнд булшлах:** Орон нутагт гоц халдварт болон халдварт өвчин гарсан үед шалгуур үзүүлэлтийг хангасан газрыг сонгон, мал амьтан, тээврийн шилжилт хөдөлгөөн аль болох бага хийх, үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахаар тооцоолж устгах, булшлах үйл ажиллагааг зэрэг гүйцэтгэнэ. Энэ нь гоц халдварт өвчин гарсан үед орон нутагт хэрэглэхэд тохиромжтой, түгээмэл хэрэглэдэг арга юм.



Булшлах газрыг сонгоод устгах малын төрөл, тооноос хамааран тэгш өнцөгт хэлбэрийн нүхийг ухаж бэлтгэнэ. Нүхний хэмжээ нь булшлах малын тоо, төрлөөс шууд хамаарна. Үхсэн болон зориуд устгасан мал амьтны хүүр, сэгзэм, бусад халдвартай материалыг халдваргүйжүүлэлт хийсний дараа газрын хөрсөнд булаах аргаар булшина. Булаах ажлыг гүйцэтгэж байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг сайтар хангах, хүн, мал, амьтан, шувуунд халдвар дамжихаас сэргийлэн булшлах ажлыг богино хугацаанд түргэн шуурхай гүйцэтгэх, байгаль орчинд ямар нэгэн хор, аюулгүй байх нөхцлийг тооцсон байвал зохинo.